



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 13-аадар

Дугаар 4/156

Мандзловь

Г

Авто замын хөдөлгөөнийг түр  
хугацаагаар хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Нийт нутаг дэвсгэрт цаг агаарын аюулт үзэгдэл үүссэнтэй холбогдуулан Төв, Улаанбаатар, Дундговь, Өмнөговь чиглэлийн авто замаар зорчих тэзврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2018 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн 09:00 цагаас эхлэн 2018 оны 04 дүгээр сарын 13-ний 20:00 цаг хүртэл хугацаагаар түр хязгаарласугай.

Хоёр. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг аймаг, сум, баг, ард иргэдэд, малчдад түргэн шуурхай хүргэж, удирдлагыг үнэн, зөв мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Онцгой байдлын газар /хурандаа Я. Алтанхундага/, Ус цаг уур орчны шинжилгээний алба /Я. Мажаасүрэн/-т үүрэг болгосугай.

Гурав. Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн газар /дэд хурандаа Ц. Сугаржав/, Автотээврийн төв /Ц. Бямбацогт/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О. БАТ-ЭРДЭНЭ



0200495